

БАТЛАВ:ЗАХИРАЛ



Ц. БАТБААТАР

**ШУТИС, ДаТС-ийн 2022-2023 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН НАМРЫН
УЛИРЛЫН “ЭРДМИЙН БАЯР” ТӨГСӨЛТИЙН ЁСЛОЛЫН АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨР, УДИРДАМЖ**

ШУТИС, ДаТС-ийн 2022-2023 оны хичээлийн жилийн намрын улирлын 52 дахь удаагийн “Эрдмийн баяр” төгсөлтийн ёслолын ажиллагааг тэмдэглэн өнгөрүүлэх гэж байна.

Арга хэмжээний зорилго:

ШУТИС-ийн 2022-2023 оны хичээлийн жилийн намрын улиралд төгсөж буй нийт суралцагчдад “Эрдмийн баяр” төгсөлтийн ажиллагааг ёслол төгөлдөр зохион байгуулахад оршино.

Хамрах хүрээ:

ШУТИС-ийн эрдэмтэн багш, ажилтан, нийт төгсөгчид, гэр бүл, найз нөхөд оролцоно.

Хэзээ: 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр 11:00-15:30 цагт

Хаана: ДаТС-ийн төв байр 2 давхарт “Хурлын танхим”

Төгсөгчдийн тоо:

- Магистр 31
- Бакалавр 75
- Нийт 106

Арга хэмжээний зохион байгуулалт:

Төгсөгчдийн баярын үйл ажиллагааг Технологийн салбарын хамт олон зохион байгуулна.

Анхааруулга:

- “Эрдмийн баяр” төгсөлтийн ёслолын ажиллагаанд оролцож буй нийт төгсөгчид 30 минутын өмнө хүрэлцэн ирж суудлаа эзэлнэ.
- Бүх түвшний төгсөгчид эрдмийн баярын ёслолын өмсгөлөө өмссөн байна.

**НЭГ: “ЭРДМИЙН БАЯР” ТӨГСӨЛТИЙН ЁСЛОЛЫН
АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР**

- 10:30-11:00 ДаТС танилцуулга, видео, дуу
- 11:00-11.10 Нээлт хөтлөгч
- 11:10-11:20 ДаТС-ийн удирдлагууд, хүндэт зочдыг танилцуулна.
- 11:20-11:30 Монгол улсын төрийн дуулал эгшиглэнэ
- 11:30-11:40 ДаТС-ийн Захирал доктор, дэд профессор Ц.Батбаатар “ЭРДМИЙН БАЯР”-ын ёслолын ажиллагааг нээж үг хэлнэ.
- 11:40-11:50 ДаТС-ийн оюутны сүлд дуу дуулах.
- 11:50-12:00 Төгсөгчдөд диплом олгох захирлын тушаалыг уншиж танилцуулна.
- 12:00-12:10 ШУТИС-ийн онцлох дипломтой төгссөн төгсөгчдөд диплом гардуулах үйл ажиллагаа
- 12:10-12:20 Төгсөгчдөдөө хүндэтгэл үзүүлэн “Онцлох дипломтой төгсөгч” үг хэлнэ.
- 12:20-12:25 Нийт төгсөгчдөдөө хандаж зөвлөх профессор, доктор профессор Ж.Амгалан үг хэлнэ.
- 12:25-12:30 Ая дууны мэндчилгээ
- 12:45-13:00 Дархан-Уул аймаг дахь Технологийн Сургуулийн шилдэг төгсөгчдийн шагнал гардуулна.
- 13:00-13:30 Эрдэмтэн нарийн бичгийн дарга доктор, дэд профессор Д. Баясгалан төгсөгчдөд хандан үг хэлнэ.
- 13:30-13:35 Магистрын төгсөгчдөд диплом гардуулах үйл ажиллагаа
- 13:35-14:30 Бакалаврын төгсөгчдөд диплом гардуулах үйл ажиллагаа
- 14:30-14:40 Төгсөгч оюутны тангараг өргөх ёслол /малгай шидэх ёслол/
- 14:40-14:50 ДаТС-ийн оюутны сүлд дууг нийт төгсөгчид болон эрдэмтэн багш нар дуулна.
- 14:50-15:00 ДаТС-ийн Сургалт, чанарын албаны дарга У.Эрдэнэболд ёслолын үйл ажиллагааг хааж үг хэлнэ.
- 15:00-15:30 Дурсгалын зураг авалт.

ХОЁР: “ЭРДМИЙН БАЯР” ТӨГСӨЛТИЙН ЁСЛОЛЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ

Сургалт, чанарын албанд өгөх зөвлөмж:

- Сургалт, чанарын алба, төгсөлтийн нарийн бичгийн дарга, оюутны хөгжил төгсөлтийн ёслолын ажиллагааг хамтран зохион байгуулна.
- Диплом гардан авах төгсөгчдийн нэрсийн жагсаалтыг гарган арга хэмжээ хөтлөх хөтлөгчид мэдээлэл өгсөн байна.
- Төгсөлтийн хуваарь, дуудах нэрсийн дарааллын дагуу төгсөгчдийн бүх дипломыг бэлтгэн бэлэн болгосон байна.
- Хавсралт 1-т заасны дагуу суудал хуваарилалтыг хийж хариуцсан салбар тэнхимийн багш нарт хүлээлгэн өгч мэдээлэл хүргүүлсэн байна.
- Үг хэлэх профессор багш, төгсөгчийн бэлтгэл ажлыг хангуулж хөтлөгчид нэрсийг хүргүүлсэн байна.
- Төгсөгчдийг сургуулийн орчинд дурсгалын зураг татуулах боломж бүхий зориулалтын талбайг тохиромжтой байршилд засаж тохижуулах ажлыг хариуцан зохион байгуулна.
- Хоцорсон оюутны дипломыг буцаан авч ёслолын бус цагаар гардуулна.

Төгсөлтийн нарийн бичгийн дарга нарт өгөх зөвлөмж:

- Төгсөлтийн ёслолын ажиллагааны зохион байгуулалтын удирдамжийг салбар тэнхимийн оюутнуудаа эрдмийн баярт биеэр оролцох эсэх тухай мэдээллийг авч, ирц бүртгэлийг тодорхой болгож сургалтын албанд мэдээлэх
- Салбар тэнхимийн оюутнуудыг ёслолын ажиллагааны хуваарийн дагуу цагт нь бүртгэж оруулна.
- Үг хэлэх сургуулийн төлөөлөл профессор багш, нэр хүндтэй төгсөгчидтэй холбогдож, үйл ажиллагааны хөтөлбөрийг урьдчилан танилцуулж, үгийг бэлдүүлж үйл ажиллагаанд оролцуулна.


Төгсөгчдөд өгөх зөвлөмж:

- Төгсөлтийн ёслолын үйл ажиллагаа 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 11:00 цагаас хөтөлбөрийн дагуу зохион байгуулагдана.
- Төгсөгчид хуваарьт цагаас 1 цагийн өмнө ирж, арга хэмжээ эхлэхээс 30 минутын өмнө суудлаа эзэлсэн байна.
- Нийт төгсөгчид хурлын танхимд өөрийн хуваарилалт бүхий суудалд суух бөгөөд гардуулах хуваарилалтын дагуу дипломоо гардан авна.
- Нийт төгсөгчид диплом гардуулах хөтөлбөр, мэдээллийг нарийн бичгийн дарга нараараа дамжуулан авсан байна.

Эцэг, эхчүүдэд өгөх зөвлөмж:

- Төгсөгчдийн ар гэрийнхэн бэлтгэсэн зориулалтын талбайд дурсгалын зураг татуулж болно.
- Хурлын танхимд эцэг, эхчүүдэд зориулсан хуваарьт суудлуудад сууж ёслолын үйл ажиллагаанд оролцох боломжтой.

ХАВСРАЛТ: СУУДЛЫН ХУВААРИЛАЛТ



Орох
хаалга

- 1-р эгнээнд
- 2-р эгнээнд
- 3-р эгнээнд
- 4-р эгнээнд
- 5-р эгнээнд
- 6-р эгнээнд
- 7-р эгнээнд
- 8-р эгнээнд
- 9-р эгнээнд
- 10-р эгнээнд

Эрдмийн зөвлөлийн гишүүд

Багш нар

Магистрын төгсөгчид (БМТИ, МУТИ, СМ)

Магистрын төгсөгчид (ЦС, ХҮТИЭА, УУАТ, БС, БУ, ТҮТ, УУМ)

Бакалаврын төгсөгчид (ИБУБИ, БМТИ, МУТИ, ҮМ, УУАТ, УУЦТТ)

Бакалаврын төгсөгчид (ЦС)

Бакалаврын төгсөгчид (ДЦС)

Бакалаврын төгсөгчид (ПХ, ЭХМ, СМ, ХАСК, ЦСА)

Төгсөгчдийн гэр бүл, найз нөхөд

Төгсөгчдийн гэр бүл, найз нөхөд

Орох
хаалга